



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН
ТАВАН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЛОГО БА ШОШГОНЫ ЗАГВАР**

2020.08.25

ТАВАН БРЭНД



НООЛУУР, НООЛУУРАН
БҮТЭГДЭХҮҮН /Эрчим хар
үүлдрийн ямаа/

1



СҮҮ, СҮҮН БОЛОН
ХӨӨВӨР БҮТЭЭГДЭХҮҮН
/Эрчимийн сарлаг/

3



СУР, СУРАН ЭДЛЭЛИЙН
БҮТЭЭГДЭХҮҮН

5



СҮҮ, СҮҮН
БҮТЭЭГДЭХҮҮН /Эрчим
хар үүлдрийн ямаа/

2




ЖИМС, ЖИМСГЭНИЙ
БҮТЭЭГДЭХҮҮН

4

НООЛУУР, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөний код



Ямаа бол дэлхийн халуун, дулаан, сэрүүн, хүйтэн бүс бүслүүрт жигд тархалттай мал. Түүнийг сүү, мах, ноолуур, ноосны чиглэлээр төрөлжүүлэн үржүүлэх ба Ази, Африк, Латин Америкийн нэлээд орнуудад бага ашиг шимтэй нутгийн ямаа зонхилдог. Малын ашиг шимийн чиглэл нь тухайн байгаль, цаг уурын нөхцөл, улс орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, шаардлага, хөгжлийн төвшин, маллагааны уламжлалт арга ажиллагаа зэргээс шууд хамаарна.

Дэлхийн зах зээл дээр нарийн бөгөөд голч, уртаараа жигдхэн ноолуур, түүгээр хийсэн бүтээгдэхүүн хамгийн өндөр үнэлэгддэг. Монголын ямааны ноолуур тэр шаардлагыг хангадаг учир эрэлт хэрэгцээ ихтэй байгаа юм. Иймд Монгол Улсад ямааг ноолуурын чиглэлээр үржүүлэхдээ түүхий эдийн чанарт өөрөөр хэлбэл ноолуурын голч, уртад онцгой анхаарах учиртай.

“Эрчим хар үүлдрийн ямаа” түүнээс гарсан ноолуур, ноолууран бүтээгдэхүүн бол Төмөрбулаг сумын топ брэнд бүтээгдэхүүн төдийгүй Монгол улс болон дэлхийд гайхуулдаг юм.

Бүтээгдэхүүний логог шошго хэлбэрээр хийсэн ба ямар ч ноолууран бүтээгдэхүүнд тохирсон болно. Логог наадаг шошго, цаасан шошго, болон тэмдэг, бэлэг дурсгалын зүйлс, хэвлэл сурталчилгаанд ашиглахад тохиромжтой байдлаар хийж гүйцэтгэлээ. Өнгийг зөөлөн өрмөн шаргал дэвсгэр дээр “Эрчим хар үүлдрийн ямаа” түүний хар өнгөөр нь билэгдэж зурлаа.



Лого дизайн: Төмөрбулаг сумын уугуул
зураач, дизайнер Шарбандийн Цогсайхан

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөний код

● C-100 M-50 Y-0 K-0

● C-0 M-5 Y-25 K-100

Ямаан сүрэг дэлхийн халуун, хүйтэн бүс бүслүүрийн янз бүрийн цаг уур, байгаль, орчинд сайн зохицдог өргөн тархалттай мал юм. Дэлхийн ямааны тоо жил бүр тогтвортой өсөж, ашиг шимийн тодорхой чиглэлээр төрөлжсөн үүлдэр, хэвшил нэмэгдсээр байна.

Ямааны сүүг Төмөрбулаг сумын малчид өргөн ашиглаж ирсэн уламжлалтай. Ямааны сүүгээр төрөл бүрийн цагаан идээ, түүний дотроос олон янзын бяслаг хийдэг, борлуулалт маш сайтай. Ямааг 6, 7-р сард саалинд зохион байгуулалттайгаар хамруулж байсан туршлагатай. Тухайлбал, саалийн ямааны сууриудыг аймгийн төвийн ойролцоо нүүлгэн түр нутаглуулж, албан байгууллага, иргэд тэнд очиж ямаа сааж, сүү, цагаан идээ хийж өргөн ашиглаж байв. Малчид ч ямааныхаа сүүг дотоод хэрэгцээндээ ашиглаж заншсан.

“Эрчим хар үүлдрийн ямаа”-ны сүүг газар дээр нь худалдан авч, үйлдвэрийн аргаар боловсруулан кальцтай цөрөм зэрэг бүтээгдэхүүн хийж хүнсний зориулалтаар худалдаалж байна. Нутгийн малчид ямааны сүүгээр эзэгий, цагаан тос хийж өвөл, хаврын улиралд хүнсэнд их хэрэглэдэг.

Бүтээгдэхүүний логог шошго хэлбэрээр хийсэн ба ямар ч цагаан идээны савлагаанд тохирсон болно. Логог наадаг шошго, цаасан шошго, болон тэмдэг, бэлэг дурсгалын зүйлс, хэвлэл сурталчилгаанд ашиглахад тохиромжтой байдлаар хийж гүйцэтгэлээ. Өнгийг зөөлөн өрмөн шаргал дэвсгэр дээр цэнхэр өнгөөр зурж гүйцэтгэлээ.



Лого дизайн: Төмөрбулаг сумын уугуул зураач, дизайнер Шарбандийн Цогсайхан

СҮҮ, СҮҮН БОЛОН ХӨӨВӨР БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөний код

● C-100 M-91 Y-32 K-28

● C-0 M-5 Y-25 K-100

Сарлаг бол үхрийн төрөлд багтдаг тусгай нэг зүйл мал болно. Сарлагийг Гималайн салбар уулс, тэнгэр уул, Алтай Хангай, Хөвсгөлийн уулархаг нутагт эрт дээр үеэс үржүүлж ирсэн байна. Сарлагийн өвөг нь одоо ч Төвдийн ууланд амьдарч буй зэрлэг сарлаг юм. Энэ амьтныг Монголчууд сарлаг, Киргизууд топос, түвдүүд “яага” гэж нэрлэдэг. Сарлаг нь манай орны уулархаг, ойт хээрийн бүс нутагт 13 аймаг 132 суманд тархсан байна. Эдгээрээс хамгийн олон сарлагтай нь Архангай, Хөвсгөл, Завхан, Өвөрхангай, Баянхонгор аймаг юм.

Сарлагийн 50 гаруй хувь нь далайн түвшнээс 2000 метрээс дээш, 40 орчим хувь нь 1600–2000 метрийн өндөрт байршиж, бусад төрлийн мал бэлчихэд тохиромжгүй нутгийн бэлчээр ус ашиглаж, арчилгаа маллагааны ердийн нөхцөлд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул эдийн засгийн үр ашиг сайтай мал юм.

Сарлагийн мах миоглобин ихтэй, тэр нь агаарын хүчилтөрөгчтэй амархан исэлдэж махыг хүрэн улаан өнгөтэй болгоно. Сарлагийн өөх “А” аминдэмийг үүсгэгч каротин ихтэй учир тод шаргал өнгөтэй. Түүнчлэн мах нь харьцангуй бүдүүвтэр ширхэгтэй, бараавтар, мах өөхний алаглалт багатай боловч энэ бүхэн нь чанарыг бууруулах биш, харин ч өөх тос–уургийн харьцаа зохимжтой, уураг, витаминар баялаг болохыг харуулна. Сарлагийн мах хүнсний хэрэгцээ хангах болон гадаадын зах зээлд үнэлэгдэх байдлаараа үхрийнхтэй нэгэн адил юм.

Сарлагийн сүүний нийт гарцын хэмжээ хөхүүл явах хугацаатай шууд уялдаатай. Тухайлбал 2–3 дугаар сард тугаллавал дунджаар 740, дөрөвдүгээр сард бол 670, тавдугаар сард бол 600, зургаадугаар сард бол 560 литр байна. Сарлагийн сүү маш өтгөн дунджаар тослог нь 7.2, уураг 5.3, чихэрлэг 5.2 хувь байх бөгөөд ялангуяа сааль татрах 9 дүгээр сараас бүр өтгөрч 10–11 сард тослог нь 9–12 хувьд хүрдэг. Сарлаг хүйтэнд маш их тэсвэртэй мал юм.

Бүтээгдэхүүний логог шошго хэлбэрээр хийсэн ба ямар ч цагаан идээны савлагаанд тохирсон болно. Логог наадаг шошго, цаасан шошго, болон тэмдэг, бэлэг дурсгалын зүйлс, хэвлэл сурталчилгаанд ашиглахад тохиромжтой байдлаар хийж гүйцэтгэлээ. Өнгийг зөөлөн өрмөн шаргал дэвсгэр дээр хар хөх өнгөөр зурж гүйцэтгэлээ.



Лого дизайн: Төмөрбулаг сумын уугуул
зураач, дизайнер Шарбандийн Цогсайхан

ЖИМС, ЖИМСГЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөний код

● C-97 M-32 Y-100 K-26

● C-0 M-5 Y-25 K-100

Жимс гэдэг нь цэцэгт ургамлын цэцэгний тодорхой эдээс бий болдог зүйл юм. Жимс нь олон ургамалын хувьд үр тараах үүрэгтэй байдаг. Мөн олон төрлийн ургамлын үр жимсийг хүн, амьтад хүнсэнд хэрэглэж, үрийг нь тараангаа илчлэг олж авдаг симбиоз харилцаатай байдаг

Хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг зохицуулах, хүч чадлыг нэмэгдүүлэх, эрүүл чийрэг өсөж хөгжихөд жимс, жимсгэнэ нэн чухал. Хүн хоногт 300 гаас доошгүй, жилд 109—112 кг жимс, жимсгэнэ, түүний бүтээгдэхүүнээр хийсэн хүнс тэжээл, ундааны зүйл хэрэглэх шаардлагатай гэж үздэг байна.

Жимс, жимсгэнэ бол чихэрлэг ихтэй, олон янзын органик хүчил, бичил язгуур махбод, төрөл бүрийн витамин агуулсан байдаг учир хүнс тэжээлээс гадна эмийн үйлдвэрийн үнэт түүхий эд болно.

Бөөрөлзгөнө, нэрс, гүзээлзгэнэ, үхрийн нүд, аньс зэрэг жимс, жимсгэнэ нь зүрх мэдрэл, цусны даралт ихдэх, цус багадах, халуурах, чийгтэх зэрэг элдэв өвчинг анагаах эмэнд хэрэглэгдэнэ. Иймээс эдгээр жимсийг түүж эмийн санд тушаах, гэрийн эмийн сан байгуулж ашигладаг болохын тулд цэцэглэх, үр жимс бүрэн боловсрох, түүх хугацааг сайн мэддэг байх нь чухал юм.

Төмөрбулаг сумын нутагт орших 100–аад километр үргэлжлэх Эрчимийн нурууны өндөр 2200м. Ноён оргил болох Урандөш хайрхан нь унтарсан галт уул ба өндөр нь 2471м. Энэ нурууны ай сав газруудаар нэрс, гүзээлзгэнэ, үхрийн нүд, аньс, улаалзгана зэрэг олон төрлийн жимс, жимсгэнэ ургадаг. Нутгийн иргэд Эрчимийн нурууныхаа жимс, жимсгэнийг түүж төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ онцлогтой.

Бүтээгдэхүүний логог шошго хэлбэрээр хийсэн ба ямар ч савлагаанд тохирсон болно. Логог наадаг шошго, цаасан шошго, болон тэмдэг, бэлэг дурсгалын зүйлс, хэвлэл сурталчилгаанд ашиглахад тохиромжтой байдлаар хийж гүйцэтгэлээ. Өнгийг зөөлөн өрмөн шаргал дэвсгэр дээр ногоон өнгөөр зурж гүйцэтгэлээ.

СУР, СУРАН ЭДЛЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөний код

● C-50 M-76 Y-83 K-73

● C-0 M-5 Y-25 K-100

Малаас гарсан түүхий эд маш чанартай байдаг. Тиймээс малын арьс ширээ өөрсдөө боловсруулж, тэр тусмаа малчдад хэрэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаараа онцлог юм. Ер нь сур, суран бүтээгдэхүүн маш чанартай, олон жилийн эдэлгээ даах чадвартай байдаг. Манай малчид баг, сумын малчдаас гадна зэргэлдээх аймаг, сумдын малчдад бүтээгдэхүүн борлуулах нь чухал юм. Энэ бол нэг брэнд бүтээгдэхүүн болно.

- | | |
|------------|----------------|
| – Бугуйл | – Ташуур |
| – Хазаар | – Ганзага |
| – Ногт | – Дөрөөний сур |
| – Чөдөр | – Жирэм |
| – Эмээл | – Цулбуур |
| – Даруулга | – Жолоо |

Бүтээгдэхүүний логог шошго хэлбэрээр хийсэн ба ямар ч савлагаанд тохирсон болно. Логог наадаг шошго, цаасан шошго, болон тэмдэг, бэлэг дурсгалын зүйлс, хэвлэл сурталчилгаанд ашиглахад тохиромжтой байдлаар хийж гүйцэтгэлээ. Өнгийг зөөлөн өрмөн шаргал дэвсгэр дээр бор өнгөөр зурж гүйцэтгэлээ.